




БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН ХҮН АМ, ӨРХИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ /2019 ОН/



ӨЛГИЙ ХОТ 2020 он

АГУУЛГА

1.Судалгааны агуулга, зорилт	4
2. Хүн ам зүйн байдал	5
3.Хүн амын шилжих хөдөлгөөн	6
4.Суурин хүн амын бүтэц ба өсөлт	9
5.Хүн ам зүйн үзүүлэлтүүд	13
6.Өрхийн тоо	15
7.Ажиллагсад салбарын ангилалаар	16
8.Хүн амын хүйс, байршил	20
9.Хүн амын дундаж наслалт	25
10. Өрхийн ам бүлийн байдал	28
11.Хөгжлийн бэрхшээлтэй хүний тоо	27
12. Хүн амын нийгмийн асуудал	28
13. Хүн ам өрхийн бүртгэл	29
14. Дүгнэлт	30
15.Ашигласан ном, материал	31

_____ о О о _____

Танилцуулгыг хянан, тохиосон:

Н.Ерлан

Танилцуулгыг хийж нэгтгэсэн, хянан боловсруулсан:

Х.Бахыт

Санал хүсэлт байвал доорх
хаягаар холбоо барина уу.

Баян-Өлгий аймгийн Статистикийн хэлтэс
Засаг даргын тамгын газрын байр

E-mail: bayan-ulgii@nso.mn, bakhat@nso.mn

Утас: 70422322

Интернэт хаяг: [//www.nso.mn/bayan-ulgii.nso.mn/](http://www.nso.mn/bayan-ulgii.nso.mn/)

Баян-Өлгий аймгийн Статистикийн хэлтэс

Өлгий хот, 2020 оны 6 сар



БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН ХҮН АМ, ӨРХИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ, 2019 ОНД

А. Судалгааны зорилго

Баян-Өлгий аймгийн хүн ам зүйн үзүүлэлтүүдийн өнөөгийн түвшин, Монгол улсын хэмжээнд болон бүс нутгийн хэмжээнд ямар түвшинд явж байгаа, хүн ам зүйн байдал, өсөлт, бууралт, шилжих хөдөлгөөний хандлага, бүтэц, ачаалал, ажил эрхлэлт, ажилгүйчүүдийн түвшинг тооцож, үнэлэлт, дүгнэлт өгөхөд орших ба мөн тус аймгийн удирдлага болон хэрэглэгчдийг хүн ам, өрхийн төлөв байдлын талаар дэлгэрэнгүй мэдээллээр хангахад зорилго нь орших болно. 2019 оны хувьд хүн ам, орон сууцны 2020 оны ээлжит тооллогын бэлтгэлийг хангах, хүн ам өрхийн бүртгэлийн мэдээллийн цахим сангийн баяжилтыг сайжруулах, шинээр нэмэгдсэн тооллогын 9 үзүүлэлтүүдийг багийн түвшинд бүрэн нөхөх зэрэг хүн ам, өрхийн мэдээллийг сайжруулах чиглэлд ихээхэн ажил хийгдсэн. Хүн ам орон сууцны тооллого нь бие даасан хуулийн хүрээнд зохион байгуулагдаж тооллогыг мэдээлэл цуглуулалтыг хосолмол буюу бүртгэл, нэмж 10 хувийг уламжлалт аргаар явуулахаар болсон. Төр засгаас авч хэрэгжүүлсэн бодлого шийдвэрийн хэрэгжилт, төсөл хөтөлбөрийн үр дүнг дүгнэж үнэлэх, цаашдын бодлого, зорилтоо тодорхойлох, хэрэглэгчдийн тоон мэдээллийн хэрэглээнд статистикийн шинжилгээний аргуудыг ашиглан шийдвэр гаргахад шаардлагатай мэдээллийг боловсруулах, зохистой ашиглахад үндсэн хэрэгсэл болно. Статистикийн салбарыг хөгжүүлэх дунд хугацааны үндэсний хөтөлбөрт Статистикийн тогтолцоог бэхжүүлэх, аргачлал, ангилал, шинжилгээ, судалгааг төгөлдөржүүлэх, үндэсний тооцооны системийг нэвтрүүлэх, салбарын статистикийг хөгжүүлэх, анхан шатнаас гаргаж буй статистикийн мэдээ, тайлангийн бодит байдлыг хангах, хүний нөөцийн чадавхыг дээшлүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ гэж заасан байдаг. Өмнөх жилүүдийн хүн ам, нийгмийн статистикийг хөгжүүлэх дэд зорилт нь хүн ам өрхийн мэдээллийн сангийн баяжилтыг тогтмолжуулж, бүртгэлийг сайжруулж, хүн ам, өрхийн мэдээллийн нэгдсэн цахим сан, статистикийн мэдээллийн нэгдсэн сангийн хэрэглээг нэмэгдүүлэх, үзүүлэлтүүдийг сум, багийн түвшинд баяжуулан олон жилийн динамик эгнээ үүсгэх, хүн ам зүй, нийгмийн статистикийн мэдээллийн чанарыг дээшлүүлэн олон улсын хэмжээнд хэрэглэж байгаа нийтлэг арга зүйд нийцүүлэх, ядуурал, ажилгүйдэл, хүн амын амьжиргааны түвшин, хэрэглээний үндсэн үзүүлэлтүүдийг орон нутгийн түвшинд тооцдог болгоход чиглүүлэх зорилт дэвшүүлж эдгээр зорилтуудыг хэрэгжүүлснээр тодорхой үр дүнд хүрсэн. Жил бүр хүний хөгжил, хүн ам зүйн үндсэн үзүүлэлтүүдийг аймаг болон бүс нутгаар тооцож зэрэгцүүлэх, орон нутгийн түвшинд хүн ам зүйн үзүүлэлтүүдийг тооцох, улсын дундажтай харьцуулсан судалгаа хийх үнэлэлт дүгнэлт хийх шаардлага зүй ёсоор гарч байна.

Б. Судалгааны агуулга

Аливаа улсын нийгэм эдийг засгийн хөгжил нь тухайн орон хүн ам зүйн бодлогоо хэрхэн боловсруулж, хэрхэн яаж хэрэгжүүлэхээс шууд шалтгаална. Эдийн засаг, нийгмийн хөгжилд хүн амын тоо, насны бүтэц, өсөлтийн түвшин гэсэн 3 гол хүчин зүйл нөлөөлнө. Хүн амын өсөлт, бүтэц, байршил болон түүнд гарч буй өөрчлөлтүүд, үйлдвэрлэл ба хэрэглээний тогтвортой бус хандлага, өсөн нэмэгдэж буй ядуурал, ажилгүйдэл, хүрээлэн буй орчны бохирдол зэрэг хүчин зүйлсийг харилцан уялдаатай авч үзэх шаардлага гардаг.

Хүн амын өсөлтийн түвшин өндөр байх тусам хөрөнгө оруулалт өндөр байдаг гэсэн үзэл баримтлал ч байдаг. Энэ талаар авч үзэхэд боловсролын түвшинээс хамааран

хүн амын өсөлт, нөхөн үржихүйн үзүүлэлтүүд ихээхэн ялгаатай гардагийг улсын хэмжээнд явагдсан судалгаануудад тусгасан байдаг. Хүн амын тогтвортой өсөлтийн хангах гол үзүүлэлт бол хүн амын цэвэр өсөлт мөн. Эдгээр шаардлагын үүднээс сүүлийн 4 жилийн хүн ам, өрхийн тоон үзүүлэлтүүдийн төлөв байдлын харьцуулсан, зэрэгцүүлсэн судалгааг хийсэн болно.



ХҮН АМ ЗҮЙН БАЙДАЛ


АЙМГИЙН ХҮН АМЫН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	2016	2017	2018	2019	2019 % 2018
Хүн амын тоо	тоо	99346	101591	103765	103908	100.1
Төрсөн хүүхэд- бүгд	тоо	2805	2914	3024	3141	103.9
1000 хүнд ногдох төрөлт	коэф	28.2	28.7	29.1	30.2	103.8
Нас барсан- бүгд	тоо	522	446	493	579	117.4
1000 хүнд ногдох нас баралт	коэф	5.3	4.4	4.8	5.6	116.7
Цэвэр өсөлт: 1000 хүнд ногдох	коэф	22.8	24.3	24.4	24.7	101.2
Эдийн засгийн идэвхтэй хүн ам	тоо	43940	53148	55772	34007	61.0
Ажиллагсдын тоо	тоо	39873	46578	48758	25779	52.9
Ажилгүй иргэн	тоо	4067	6570	7014	8228	117.3
Ажилгүйдлийн түвшин	хувь	9.3	12.4	12.6	24.2	192.1

2019 оны жилийн эцсийн байдлаар аймгийн суурин хүн амын тоо 103.9 мянга болж урьд оныхоос 143 хүнээр буюу 0.1 хувиар нэмэгдсэн. Энэ нь тухайн жилийн хүн амын ердийн хөдөлгөөнийг бүрэн тусгаж, хүн ам өрхийн мэдээллийн санд төрөлт, нас баралтыг улсын бүртгэлийн хэлтсээс сар бүр гаргуулан авч цахим санд оруулж, иргэний мэдээллийн сангийн зөрүүг арилгаж, бичиг баримтын зөрчилтэй хүмүүсийн зөрчлийн арилгуулж мэдээллийн санд тусгагдаж цэгцлэгдсэн, сүүлийн жилүүдэд ялангуяа 2019 оны төрөлт улсын дунджаас дээгүүр байгаа ба 1000 хүнд ногдох төрөлт 30.2, нас баралт 5.6, цэвэр өсөлт 24.7 болсон нь өмнөх оны мөн үеэс 1000 ногдох төрөлт 1.1 пунктээр, нас баралт 0.8 пунктээр, хүн амын ердийн цэвэр өсөлт 0.3 пунктээр тус тус өссөн байна. Суурин хүн амын тоо 143 хүнээр буюу 0.1 хувиар, өрхийн тоо ялимгүй бага зэрэг өсөхөд 6 сараас дээш хугацаагаар гадаадад амьдарч буй хүн амын тоо 5250 болсон нь гадаад шилжилт хөдөлгөөн нэмэгдсэнтэй холбоотойгоор суурин хүн амын тоо төдийлөн өсөөгүй байна. Ажиллах хүчний судалгааны үр дүнгээр тодорхойлогддог хөдөлмөрийн статистикийн үзүүлэлтүүд өнгөрсөн оноос буурч гарсан ба үүнд эдийн засгийн идэвхтэй хүн ам 39.0 хувиар, ажиллагсдын тоо 47.1 хувиар тус тус буурснаас улбаалан ажилгүй иргэний тоо 17.3 хувиар, ажилгүйдлийн түвшин 92.1 хувь буюу 1.9 дахин тус тус өсч нэмэгдсэн байна. Ажиллагсдын тоо 25779 болж өмнөх оноос 47.1 хувиар багасаж, ажилгүйчүүдийн тоо 8228 байгаа нь өмнөх оноос 17.3 хувиар өсч, ажилгүйдлийн түвшин 24.2 хувьд хүрсэн нь улсын дунджаас 2.4 дахин их байна. Аймгийн нийт хүн амын 61.3 хувийг хөдөлмөрийн насны хүн ам эзэлж байгаа ажиллах хүчний хангалттай нөөц байгааг харуулж байна.

ХҮН АМЫН ЦЭВЭР ӨСӨЛТ

Хүн амын 35.3 хувийг 0-14 хүртэлх насны хүүхдүүд, 61.3 хувь нь 15-64 насны хүмүүс байгаа нь хөдөлмөрийн хангалттай нөөц байгааг харуулж байгаа ба, 3.4 хувийг 65, түүнээс дээш насны ахмад хүмүүс эзэлж байна.



Хөдөлмөрийн насны 63683 хүний 25779 хүн буюу 40.5 хувь нь албан ба албан бус хөдөлмөр эрхэлж эдийн засгийн идэвхтэй байгаа ба 12.9 хувь нь ажил хөдөлмөр эрхэлдэггүй, ажил идэвхтэй хайж буй ажилгүй иргэн байна. Эдийн засгийн идэвхгүй хүн ам буюу сургуульд суралцаж байгаа, гэрийн ажилтай, өндөр настан, өндөр насны тэтгэвэр тогтоолгосон, хөгжлийн бэрхшээлтэй болон ажил хайх итгэл алдарсан зэрэг шалтгаанаар тухайн хугацаанд ажиллах хүчинд хамаарахгүй хөдөлмөрийн насны хүн амын тоо 43725 болж өмнөх оноос 1.8 дахин өссөн байна. Аймгийн хөдөлмөр, халамж үйлчилгээний газар болон сумдын засаг даргын тамгын газарт бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо жилийн эцсийн байдлаар 1221 байгаа нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 171 хүнээр буюу 16.3 хувиар өссөн байна. Нийт бүртгэлтэй ажилгүйчүүдийн 46.2 хувийг эмэгтэйчүүд, 50.0 орчим хувийг 15-34 насны залуучууд, үүний 17.1 хувь нь дээд боловсролтой залуучууд эзэлж байна.

ХҮН АМЫН ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨН

Үзүүлэлтүүд	2015	2016	2017	2018	2019
Шилжин ирэгсэд бүгд:	262	270	317	214	154
Шилжин явагсад бүгд:	1328	2570	353	199	460
Гадаад шилжилт:					
Казахстан	822	2124	405		

2019 онд 154 хүн тус аймаг руу шилжин ирж суурьшсаны 18.8 хувь нь Ховд аймгаас, 51.9 хувь нь Улаанбаатар хотоос, 8.4 хувь нь Сэлэнгэ аймгаас, 4.5 хувь нь Увс аймгаас, 16.4 хувийг үлдсэн бусад аймгуудаас шилжин суурьшсан иргэд болон их дээд сургууль төгссөн оюутанууд болон албан ажлын болон ах дүүс хамаатан садан руу шилжих шилжилт эзэлж байна. Тус аймаг руу шилжин ирэгчдийг насны бүлгээр

ангилбал 26.6 хувь 0-14 насны, 40.3 хувь 15-29 насны залуучууд, 28.6 хувь 30-54 насны, 4.5 хувь 55-аас дээш насны хүн эзэлж байна. Тус аймгаас 460 хүн шилжин явсны 244 эмэгтэйчүүд байна. Шилжин явагчдыг насны бүлгээр ангилбал 34.3 хувь 0-14 нас, 37.0 хувь 15-29 насны залуучууд, 24.3 хувь 30-54 насны, 4.3 хувь 55-аас дээш насны хүн эзэлж байна. Улсын бүртгэлийн ерөнхий газраас гадаад шилжих хөдөлгөөнийг аймгаар 2018 оноос эхлэн гаргахгүй байгаа тул 2019 онд хэчнээн хүн Казахстан улс руу шилжсэн болон Казахстангаас шилжсэн ирсэн талаарх албан ёсны тоо мэдээлэлгүй болно.

ДОТООД ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨН, ШИЛЖИН ЯВАГЧИД

Он	Шилжин явсан өрх-Бүгд	Шилжин явсан хүн ам-Бүгд	Үүнээс: насны бүтцээр			
			0-14 насны	15-29 насны	30-54 насны	55-аас дээш
2015 онд	280	822	36	230	368	109
2016 онд	105	446	75	280	72	19
2017 онд	84	353	79	191	75	8
2018 онд	61	199	44	105	47	3
2019 онд	108	460	158	116	112	74

ДОТООД ШИЛЖИХ ХӨДӨЛГӨӨН, ШИЛЖИН ИРЭГЧИД

Он	Шилжин ирсэн өрх-Бүгд	Шилжин ирсэн хүн ам-Бүгд	Үүнээс: насны бүтцээр			
			0-14 насны	15-29 насны	30-54 насны	55-аас дээш
2015 онд	61	262	85	109	56	12
2016 онд	64	270	64	140	55	11
2017 онд	75	317	81	149	80	7
2018 онд	65	214	51	105	47	11
2019 онд	36	154	41	62	45	47

ХҮН АМЫН НИЙГМИЙН ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Үзүүлэлтүүд	2016	2017	2018	2019	$\frac{2019}{2018} \%$
Хөдөлмөр эрхлээгүй хүн ам	4067	6570	7014	8228	117.3
Ядуу өрхийн тоо	7184	8596	8847	7728	87.4
Нэн ядуу өрхийн тоо	3993	4403	4530	3957	87.4
8 ба дээш ам бүлтэй өрх	1054	1119	1236	1330	107.6
Өрх толгойлсон эмэгтэй	1822	1879	1743	1785	102.4
Ганц бие өрхийн тоо	254	504	573	455	79.4
Хөгжлийн бэрхшээлтэй иргэд	4564	4608	4168	4345	104.2
Хагас өнчин хүүхдийн тоо	1862	1937	2039	2022	99.2
Бүтэн өнчин хүүхдийн тоо	273	283	200	191	95.5

*-урьдчилсан тоо

ХҮН АМ ЗҮЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Үзүүлэлтүүд	2016	2017	2018	2019	<u>2019%</u> 2018
Хүн амын тоо	99346	101591	103765	103908	100.1
Цэвэр өсөлт	22.8	24.3	24.4	24.7	101.2
Төрөлтийн ерөнхий коэффициент**	28.2	28.7	29.1	30.2	103.7
Төрөлтийн тусгай коэффициент	106.0	108.8	111.2	117.9	106.1
Төрсөн хүүхэд, Бүгд	2805	2914	3024	3141	103.9
15-49 насны эмэгтэй	26460	26794	27203	26643	97.9
1000 хүнд ногдох нас баралт	5.3	4.4	4.8	5.6	116.7
Хүйсний бүтэц: Эрэгтэй	49538	50693	51781	51854	100.1
Эмэгтэй	49808	50898	51984	52016	100.1
Хүйсний харьцаа*	99.5	99.6	99.6	99.6	100.0
Нялхсын нас баралтын коэффициент	28.2	13.0	17.2	20.7	120.4
Нялхсын эндэгдэл /0-1 нас/	79	38	52	62	119.2
1-5 хүртэлх насны хүүхдийн нас баралт	12	13	21	13	61.9
Батлуулсан гэр бүл	794	993	836	772	92.3
Гэрлэлтийн ерөнхий коэффициент	0.80	0.98	0.81	0.74	92.2
Гэрлэлтийн тусгай коэффициент**	1.2	1.5	1.2	1.2	98.2
Гэр бүл салалт	34	29	39	47	120.5
15-аас дээш насны хүн ам	65073	66388	67726	63683	94.0

*100 эрэгтэйд тооцох эмэгтэйчүүдийн тоо

** Нөхөн үржихүйн насны 1000 эмэгтэйд ногдох төрөлт

*** Гэрлэх насанд хүрсэн 100 хүнд ногдох гэрлэлт

ТӨРӨЛТИЙН ЕРӨНХИЙ КОЭФФИЦИЕНТ

Үзүүлэлтийн нэр	2015	2016	2017	2018	2019
Улсын дүн	27.1	25.9	23.9	24.5	24.4
Баян-Өлгий	28.6	28.0	28.7	29.1	29.4


Хүн ам зүйн зарим үзүүлэлтүүдийн тооцооноос үзэхэд манай аймгийн төрөлтийн ерөнхий коэффициент 2015 онд 28.6 байсан бол 2019 онд 29.4 болж 0.8 пунктээр өссөн нь нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн тоо нэмэгдэж байгааг харуулж байна. Тус аймагт төрөлтийн ерөнхий коэффициент 29.4 байгаа нь улсын дундажаас 5.0

пунктээр дээгүүр байгаа ба төрөлт нэмэгдэх тусам хүн амын тоо өсөж 1000 хүнд ногдох нас баралт тайлант онд өмнөх оноос 0.8 пунктээр өссөн байна. Төрөлтийн тусгай коэффициентээс харахад /тухайн жилийн төрөх насны (15-49 насны) 1000 эмэгтэйд ногдох амьд төрсөн хүүхдийн тоогоор илэрхийлнэ/ 2019 онд аймгийн нөхөн үржихүйн насны 1000 эмэгтэй тутамд 112 төрөлт ногдож байгаа нь улсын дундажаас 20 орчим төрөлтөөр өндөр байна. Хүйсний харьцаа нь 99.6 байгаа нь эмэгтэйчүүдийн тоо эрэгтэйчүүдээс 162 илүү байна. Эрэгтэйчүүдтэй харьцуулахад эмэгтэйчүүдийн тоо цөөхөн тоогоор их /162 хүн/ байгаа бөгөөд 100 эмэгтэйд 99.6 эрэгтэй ногдож байна.

ХҮН АМЫН НАСНЫ БҮТЭЦ СУУРИН ХҮН АМЫН ТОО, СУМААР

Сумын нэр	2016	2017	2018	2019	2019% 2018
Алтай	4212	4257	4241	4242	100.0
Алтанцөгц	2792	2814	2849	2882	101.2
Баяннуур	4913	4978	4930	4839	98.2
Бугат	3781	3790	3870	3844	99.3
Булган	5144	5183	5192	5041	97.1
Буянт	2767	2846	2818	2801	99.4
Дэлүүн	7140	7331	7437	7353	98.9
Ногооннуур	7842	7976	8044	7941	98.7
Сагсай	5137	5259	5211	5229	100.3
Толбо	4105	4169	4173	4186	100.3
Улаанхус	8357	8548	8602	8633	100.4
Цэнгэл	9149	9322	9468	9591	101.3
Өлгий	34007	35118	36930	37326	101.1
Дүн	99346	101591	103765	103908	100.1

ХҮН АМЫН ТОО, ЦЭВЭР ӨСӨЛТ /1000 ХҮНД НОГДОХ/



СУУРИН ХҮН АМЫН ТОО, НАСНЫ БҮЛГЭЭР

Сумын нэр	Бүгд	Насны бүлгээр						
		0-4	5-9	10-14	15-19	20-24	25-29	30-34
Бүгд	103908	14145	12201	10381	9785	8670	9156	7978
Өлгий	37326	5055	4201	3351	3141	2799	3608	3266
Алтай	4242	523	520	413	421	374	355	317
Алтанцөгц	2882	370	296	286	298	263	250	188
Баяннуур	4839	612	585	540	542	404	397	311
Бугат	3844	531	458	390	386	313	338	309
Булган	5041	660	570	510	502	432	439	353
Буянт	2801	368	304	255	269	256	240	184
Дэлүүн	7353	1006	865	750	773	669	616	469
Ногооннуур	7941	1133	1038	851	650	683	663	643
Сагсай	5229	771	667	553	511	470	409	366
Толбо	4186	558	466	468	410	356	365	275
Улаанхус	8633	1180	1068	974	872	804	680	580
Цэнгэл	9591	1378	1163	1040	1010	847	796	717

Сумын нэр	Насны бүлгээр							
	35-39	40-44	45-49	50-54	55-59	60-64	65-69	70+
Бүгд	6637	5912	5298	4295	3525	2427	1383	2115
Өлгий	2431	2115	2046	1690	1424	980	506	713
Алтай	289	260	213	169	137	114	44	93
Алтанцөгц	179	169	174	124	102	70	48	65
Баяннуур	287	254	275	186	173	101	63	109
Бугат	228	219	194	150	101	84	48	95
Булган	323	279	250	241	181	119	67	115
Буянт	177	173	171	112	110	87	39	56
Дэлүүн	452	438	353	292	256	162	95	157
Ногооннуур	540	473	353	256	236	175	103	144
Сагсай	316	299	224	189	156	100	81	117
Толбо	248	229	228	200	134	75	55	119
Улаанхус	585	456	414	324	245	167	112	172
Цэнгэл	582	548	403	362	270	193	122	160

Хөдөлмөрийн насны хүн ам нийт хүн амын 61.4 хувийг эзэлж, 35.2 хувийг хүүхэдүүд, 3.4 хувийг өндөр настан эзэлж байна. Хөдөлмөрийн насны 1000 хүнд 574 хүүхэд, 55 өндөр настанг асран тэжээх үүрэг ногдож байна.

СУУРИН ХҮН АМЫН ТОО, НАСНЫ БҮЛГЭЭР

Насны бүлэг	Бүгд	Эрэгтэй	Эмэгтэй
Хүн ам-Бүгд	103908	51855	52053
0-4	14145	7286	6859
5-9	12201	6162	6039
10-14	10381	5188	5193
15-19	9785	4950	4835
20-24	8670	4367	4303
25-29	9156	4593	4563
30-34	7978	4070	3908
35-39	6637	3316	3321
40-44	5912	2982	2930
45-49	5298	2543	2755
50-54	4295	2103	2192
55-59	3525	1634	1891
60-64	2427	1138	1289
65-69	1383	608	775
70-74	779	335	444
75-79	696	323	373
80-84	333	156	177
85-89	224	83	141
90-94	52	13	39
95-99	23	4	19
100+	8	1	7

Сумын нэр	Бүгд-Хүн ам	Хөдөлмөрийн нас	Хүүхэд	Өндөр настан
Өлгий	37326	23500	12607	1219
Алтай	4242	2649	1456	137
Алтанцөгц	2882	1817	952	113
Баяннуур	4839	2930	1737	172
Бугат	3844	2322	1379	143
Булган	5041	3119	1740	182
Буянт	2801	1779	927	95
Дэлүүн	7353	4480	2621	252
Ногооннуур	7941	4672	3022	247
Сагсай	5229	3040	1991	198
Толбо	4186	2520	1492	174
Улаанхус	8633	5127	3222	284
Цэнгэл	9591	5728	3581	282
Дүн	103908	63683	36727	3498

ХӨДӨЛМӨРИЙН НАСНЫ 1000 ХҮН АМД НОГДОХ ТЭЖЭЭВЭР ХҮНИЙ ТОО

Сумын нэр	Хүүхэд	Хөдөлмөрийн нас	Өндөр настан	Хөдөлмөрийн насны 1000 хүнд ногдох		
				Хүүхэд	хөдөлмөрийн насны хүн	Өндөр настан
Өлгий	12607	23500	1219	198	369	19
Алтай	1456	2649	137	23	42	2
Алтанцөгц	952	1817	113	15	29	2
Баяннуур	1737	2930	172	27	46	3
Бугат	1379	2322	143	22	36	2
Булган	1740	3119	182	27	49	3
Буянт	927	1779	95	15	28	1
Дэлүүн	2621	4480	252	41	70	4
Ногооннуур	3022	4672	247	47	73	4
Сагсай	1991	3040	198	31	48	3
Толбо	1492	2520	174	23	40	3
Улаанхус	3222	5127	284	51	81	4
Цэнгэл	3581	5728	282	56	90	4
Дүн	36727	63683	3498	577	1000	55

ХҮН АМ ЗҮЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Хүн ам зүйн ачаалал: Хөдөлмөрийн насны 100 хүнд ногдох хүүхэд, хөгшдийн харьцаагаар илэрхийлэгддэг үзүүлэлт юм.Энэ нь хөдөлмөрийн насны 100 хүн өөрөөсөө гадна хэдэн хүүхэд, хөгшдийг тэжээж байгааг хялбар байдлаар хэмжих арга юм.Өөрөөр хэлбэл, хүн амын насны бүтцээс хамааран эдийн засагт ямар ачаалал үүсч байгааг уг үзүүлэлтээр ойролцоо байдлаар хэмжиж болно.Хүн ам зүйн ачааллыг хүүхдийн, хөгшдийн болон нийт ачаалал гэж гурван янзаар тооцдог.

Хөгшрөлтийн индекс: 0-15 насны хүүхэд, 65, түүнээс дээш настай хүн амын харьцаа

Голч нас: Хүн амын тоог таллан хувааж байгаа зааг нас

Асран хамгаалагчийн харьцаа: 50-64 насны 100 эмэгтэйд ногдох 80-аас дээш насныхны харьцаа


Хүн ам зүйн ачаалал нь хөдөлмөрийн бус насны хүн амын нийгэмд үзүүлж буй ачааллыг илэрхийлдэг тул 2015 онд 62.3 байсан бол 2019 онд 54.8 болж сүүлийн 4 жилд 7.5 пунктээр буурсан байна, харин улсын түвшинд 5.8 пунктээр өссөн байна.

ХҮН АМ ЗҮЙН АЧААЛАЛ

Үзүүлэлтүүд	Насны төрөл	2015	2016	2017	2018	2019
Улсын дүн	Нийт	51.3	50.8	52	54.6	57.1
	Хүүхэд	45.5	45	45.9	48.3	50.4
	Хөгшид	5.8	5.8	6.1	6.3	6.7
Баян-Өлгий	Нийт	62.3	60.4	61	61.2	54.8
	Хүүхэд	57.1	55.4	55.8	56	47.7
	Хөгшид	5.2	5.1	5.2	5.2	7.0

Тайлбар: Хөдөлмөрийн насны 100 хүнд ногдох тэжээгдэгчийн тоо (15-аас доош, 65 ба түүнээс дээш насны хүн амын тоо) буюу хөдөлмөрийн бус насны хүн амын нийгэмд үзүүлж буй ачааллыг хүн амын насны бүлгийн бүтцээр илэрхийлнэ.

Суурин хүн амын тоо



АЖИЛЛАГСДЫН ТОО, ЭДИЙН ЗАСГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ САЛБАРААР

№	Эдийн засгийн үйл ажиллагааны салбар	2018	2019	$\frac{2019\%}{2018}$
1	Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	21581	862	4.0
2	Уул уурхай, олборлолт	62	226	364.5
3	Боловсруулах үйлдвэрлэл	3465	2,239	64.6
4	Цахилгаан, хий, уур, агааржуулалтын хангамж	304	224	73.7
5	Усан хангамж; бохир ус, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа	60	0	0.0
6	Барилга	1609	2,355	146.4
7	Бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар, үйлчилгээ	7366	3,511	47.7
8	Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	2210	1,682	76.1
9	Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ	624	276	44.2
10	Мэдээлэл, холбоо	247	38	15.4
11	Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	425	158	37.2
12	Мэргэжлийн шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	315	178	56.5
13	Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал	2295	2679	116.7
14	Боловсрол	6015	5434	90.3
15	Хүний эрүүл мэнд ба нийгмийн үйл ажиллагаа	1423	2564	180.2
16	Урлаг, үзвэр, тоглоом, наадам	316	1020	322.8
17	Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	383	1771	462.4
18	Хүн хөлслөн ажиллуулдаг өрхийн үйл ажиллагаа	58	562	969.0
Дүн		48758	25779	52.9

Тус аймагт хөдөлмөрийн насны 63773 хүний 25779 хүн буюу 40.3 хувь нь албан ба албан бус хөдөлмөр эрхэлж эдийн засгийн идэвхтэй байгаа ба 12.9 хувь нь ажил хөдөлмөр эрхэлдэггүй, ажил идэвхтэй хайж буй ажилгүй иргэн байна. Эдийн засгийн идэвхгүй хөдөлмөрийн насны хүн амын тоо 43725 болж өмнөх оноос 1.8 дахин өссөн байна. Аймгийн нийт ажиллагсдын 3.3 хувийг хөдөө аж ахуйн салбарт, 13.6 хувь нь худалдаа, 21.1 хувь нь боловсрол, 8.7 хувь нь боловсруулах үйлдвэрт, 10.4 хувь төрийн удирдлага, батлан хамгаалах, 6.5 хувь нь тээвэр ба агуулахын үйл ажиллагаа, 9.1 хувь нь барилгын, 9.9 хувь нь эрүүл мэндийн салбарт ажиллаж байна. Хүндэтгэх

шалтгаангүй ажил хөдөлмөр эрхлээгүй, ажил хөдөлмөр эрхлэх хүсэлтэй 8228 хүн байгаагийн 54.2 хувь нь буюу 4462 эмэгтэй хүмүүс эзэлж байна.

ХӨДӨЛМӨРИЙН НАСНЫ ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЭГҮЙ ХҮНИЙ ТОО

№	Сумын нэр	Нийт ажилгүй иргэн-2019 он			Бүртгэлтэй ажилгүй иргэн-ХХҮГ	
		Бүгд	Эмэгтэй	Эрэгтэй	Бүгд	Үүнээс Эмэгтэй
1	Алтай	155	84	71	7	2
2	Алтанцөгц	130	71	59	13	6
3	Баяннуур	332	150	207	23	10
4	Бугат	117	66	49	22	10
5	Булган	97	53	44	9	3
6	Буянт	174	94	80	18	8
7	Дэлүүн	582	256	375	35	14
8	Ногооннуур	311	168	142	28	12
9	Өлгий	5317	2970	2276	1077	509
10	Сагсай	144	78	66	24	10
11	Толбо	145	79	66	27	13
12	Улаанхус	320	173	148	17	9
13	Цэнгэл	404	220	183	25	11
	Дүн	8 228	4 462	3 766	1 325	617


ӨРХИЙН ТОО


Сумын нэр	2016	2017	2018	2019	2019/2018 %
Өлгий	7861	8000	8 424	8486	100.7
Алтай	1112	1108	1 101	1087	98.7
Алтанцөгц	755	747	755	748	99.1
Баяннуур	1155	1155	1 148	1146	99.8
Бугат	984	989	1 015	984	96.9
Булган	1240	1188	1 269	1300	102.4
Буянт	766	791	769	726	94.4
Дэлүүн	1637	1634	1 662	1658	99.8
Ногооннуур	1949	1989	2 001	1984	99.2
Сагсай	1269	1281	1 279	1277	99.8
Толбо	965	967	1 004	1013	100.9
Улаанхус	1826	1796	1 835	1862	101.5
Цэнгэл	1978	1981	2 044	2056	100.6
Дүн	23 497	23 626	24 306	24 327	100.1

ӨРХИЙН ТОО, БАЙРШЛААР

Сумын нэр	Өрх - Бүгд	Аймгийн төвд	Тосгонд	Сумын төвд	Хөдөөд
Өлгий	8486	8486	0	0	0
Алтай	1087	0	0	285	802
Алтанцөгц	748	0	0	220	528
Баяннуур	1146	0	0	478	668
Бугат	984	0	0	174	810
Булган	1300	0	0	284	1016
Буянт	726	0	0	200	526
Дэлүүн	1658	0	0	271	1387
Ногооннуур	1984	0	420	418	1146
Сагсай	1277	0	0	380	897
Толбо	1013	0	0	306	707
Улаанхус	1862	0	0	371	1491
Цэнгэл	2056	0	0	553	1503
Дүн	24 327	8486	420	3940	11481

ӨРХИЙН ТОО, МАЛЧИН ӨРХ






МАЛЧИН ӨРХИЙН ТОО

Сумын нэр	Малчин өрхийн тоо	Малын тоо, төрлөөр					
		Бүгд	Адуу	Үхэр	Тэмээ	Хонь	Ямаа
Өлгий	4	27 091	1 492	6 065	33	6 890	12 611
Алтай	639	154 714	9 503	15 485	359	81 541	47 826
Алтанцөгц	368	134 258	5 923	6 809	1 102	51 746	68 678
Баяннуур	539	161 224	6 305	6 652	582	56 435	91 250
Бугат	336	119 690	5 047	7 671	86	53 255	53 631
Булган	761	130 311	7 390	12 725	615	28 286	81 295
Буянт	389	131 898	4 993	9 452	204	79 878	37 371
Дэлүүн	861	228 875	10 746	20 568	327	97 945	99 289
Ногооннуур	852	241 843	10 497	13 558	636	93 779	123 373
Сагсай	683	158 957	8 524	11 610	321	86 176	52 326
Толбо	620	170 269	6 400	9 498	112	104 686	49 573
Улаанхус	1 119	221 032	9 243	18 827	806	113 740	78 416
Цэнгэл	1 532	312 602	12 957	19 662	730	141 547	137 706
Дүн	8 703	2 192 764	99 020	158 582	5 913	995 904	933 345

Хүн амын тоо урьд онтой харьцуулахад 143 хүнээр, өрхийн тоо 21 өрхөөр нэмэгдсэн байна. Нийт өрхийн 34.9 хувь нь аймгийн төвд, 16.2 хувь нь сумын төвд, 47.2 хувь нь хөдөө, 1.7 орчим хувь нь тосгонд амьдарч байна.

ХҮН АМЫН ЖИЛИЙН ӨСӨЛТ ХУВИАР




НЭГ ӨРХӨД НОГДОХ ХҮНИЙ ТОО

Сумын нэр	2016	2017	2018	2019
Алтай	3.8	3.8	3.9	4.4
Алтанцөгц	3.7	3.8	3.8	3.9
Баяннуур	4.3	4.3	4.3	3.9
Бугат	3.9	3.8	3.8	4.2
Булган	4.3	4.4	4.1	3.9
Буянт	3.6	3.6	3.7	3.9
Дэлүүн	4.5	4.5	4.5	3.8
Ногооннуур	4.0	4.0	4.0	4.4
Сагсай	4.1	4.1	4.1	4.0
Толбо	4.2	4.3	4.2	4.1
Улаанхус	4.6	4.8	4.7	4.1
Цэнгэл	4.6	4.7	4.6	4.6
Өлгий	4.4	4.4	4.4	4.7
Дүн	4.3	4.3	4.3	4.3

Нэг өрхөд ногдох хүний тоо дундажаар 4.3 байгаа ба сумуудыг авч үзэвэл Өлгий 4.7, Цэнгэл 4.6, Ногооннуур 4.4, Бугат 4.2, Дэлүүн 3.8 хүнтэй байна.


Өрхийн тоо байршлаар



Хөдөөнөөс аймаг, төв суурин газар руу, гадаад руу чиглэгдсэн шилжих хөдөлгөөн нэмэгдэх хандлагатай байгаагаас суурин газарт оршин суух хүн ам, өрхийн тоо нэмэгдэж байна.

МАЛЧДЫН ТООН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Үзүүлэлтүүд	2015	2016	2017	2018	2019	2019/2018 %
Малчин өрх	8872	8888	9261	8728	8703	99.7
Малчдын тоо	18398	18411	17200	13993	13746	98.2
Үүнээс: 16-34 насны	7396	6927	6338	4971	4567	91.9
35-59 насны	9433	9884	8823	7553	7888	104.4
Тэтгэврийн насны	1569	1600	1862	1461	1289	88.2
Нэг малчин өрхөд ногдох мал	227	244	204	248	252	101.6




Жилийн эцсийн мал тооллогын үр дүнгээр жилийн дөрвөн улирал малаа өөрөө малладаг малчин өрх, малчдын тоо жилээс жилд багасгаж байгаа 2019 онд 8703 болж өмнөх оноос 25 өрөөр буюу 0.3 хувиар, малчдын тоо 247 буюу 1.8 хувиар тус тус багассан байна, залуу малчид буюу 16-34 насныхан өмнөх оноос 404 буюу 8.1 хувиар буурсан байна. Тийм учир төр засгаас малчдын залуу халааг бэлтгэхэд онцгой анхаарахгүй бол мал аж ахуйн салбарт хүндрэл бэрхшээл гарах төлөвтэй байна. Малчдад улсаас ноосны урамшууллыг зөвхөн малчин өрхүүдэд олгодог болсон мөн сүүлийн жилүүдэд хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний үнэ, түүний дотор ноолуурын үнэ гадаад зах зээлээс хамаарч хэлбэлзэлтэй буурч байгаа нь малчин өрхийн орлого болон амьжиргааны эх үүсвэрт нөлөөлж байна.

ХҮН АМЫН ТОО, ХҮЙСЭЭР

Сумын нэр	2018 он	2019 он	Эрэгтэй	Эмэгтэй	Өсөлт, бууралт+,-	Хувь
Дүн	103765	103908	51855	52053	143	100.1
Өлгий	36930	37326	18341	18985	396	101.1
Алтай	4241	4242	2168	2074	1	100.0
Алтанцөгц	2849	2882	1447	1435	33	101.2
Баяннуур	4930	4839	2487	2352	-91	98.2
Бугат	3870	3844	1977	1867	-26	99.3
Булган	5192	5041	2531	2510	-151	97.1
Буянт	2818	2801	1393	1408	-17	99.4
Дэлүүн	7437	7353	3644	3709	-84	98.9
Ногооннуур	8044	7941	3982	3959	-103	98.7
Сагсай	5211	5229	2606	2623	18	100.3
Толбо	4173	4186	2088	2098	13	100.3
Улаанхус	8602	8633	4349	4284	31	100.4
Цэнгэл	9468	9591	4842	4749	123	101.3


Сумын нэр	Нийт хүн ам	Эрэгтэй	Эмэгтэй	Дүнд эзлэх хувь		Хүйсийн харьцаа
				Эрэгтэй	Эмэгтэй	
Дүн	103908	51855	52053	49.9	50.1	99.6
Өлгий	37326	18341	18985	49.1	50.9	96.6
Алтай	4242	2168	2074	51.1	48.9	104.5
Алтанцөгц	2882	1447	1435	50.2	49.8	100.8
Баяннуур	4839	2487	2352	51.4	48.6	105.7
Бугат	3844	1977	1867	51.4	48.6	105.9
Булган	5041	2531	2510	50.2	49.8	100.8
Буянт	2801	1393	1408	49.7	50.3	98.9
Дэлүүн	7353	3644	3709	49.6	50.4	98.2
Ногооннуур	7941	3982	3959	50.1	49.9	100.6
Сагсай	5229	2606	2623	49.8	50.2	99.4
Толбо	4186	2088	2098	49.9	50.1	99.5
Улаанхус	8633	4349	4284	50.4	49.6	101.5
Цэнгэл	9591	4842	4749	50.5	49.5	102.0

Хүн амын тоо, хүйс, сумаар



ХҮН АМЫН ТОО, ХҮЙСЭЭР


Дээрх хүснэгтээс үзэхэд аймгийн дүнгээр эрэгтэйчүүд ба эмэгтэйчүүд хувийн жин ойролцоо түвшинд байна. Баяннуур, Алтай, Бугат, Булган, Ногооннуур, Улаанхус, Цэнгэл сумдад эрэгтэйчүүдийн хувийн жин 0.1-1.4 пунктээр давамгайлж байна. Дэлүүн, Өлгий, Буянт, Сагсай, Толбо сумуудад эмэгтэйчүүдийн хувийн жин 0.1-0.8 хүртэлх пунктээр илүү байна.



СУУРИН ХҮН АМЫН БҮТЭЦ

Хүн амын нас хүйсийн 2019 оны суврагаас харахад 0-4, 5-9, 10-14, 15-19 насны бүлгийн насны хүн амын тоо хамгийн их өргөн буюу 46.4 мянга буюу нийт хүн амын 44.7 хувийг эзэлж байгаа нь хоёр хүн тутмын нэг нь бага, идэр насны хүүхэд залуучууд эзэлж хүн амын залуу бүтэцтэй байгааг харуулж байна. 2019 онд суурин хүн амын тоо 103.9 мянга болж 105 хүнээр нэмэгдэж 0.1 хувиар өссөн байна.

ХҮН АМЫН НАС ХҮЙСНИЙ СУВАРГА 2019 ОН



Хүн амын дундаж наслалт уртассантай холбоотойгоор 60-аас дээш настай өндөр настангуудын хувийн жин нэмэгдсэн нь суврагын толгойн хэсэг өргөсөж үүний дотор эмэгтэйчүүдийн тоо эрэгтэйчүүдээс илүү байгаа нь харагдаж байна. Дээрх хүн амын нас, хүйсийн суваргаас харахад суурь хэсэг нь өргөн, дунд хэсгээрээ жигд өргөсч байгаа нь хүн ам идэрших хандлагатай байгааг харуулж байна. 2019 онд 0-4 насны хүн амын тоо 5-9 насны хүн амын тоонтой ойролцоо байгаа нь сүүлийн 5 жилд төрөлт нэмэгдсэнтэй холбоотой юм. 2019 оны 5-9, 10-14, 15-19 насны хүн амын тоо харилцан ижилхэн харьцангуй их хувийн жинг эзэлдэг нь суваргаас харагдаж байна.

ХҮН АМЫН ДУНДАЖ НАСЛАЛТ


Үзүүлэлтүүд	2015	2016	2017	2018	2019
Улсын дундаж	69.89	69.57	69.89	70.19	70.41
Үүнээс: Эрэгтэй	66.02	65.58	65.88	66.11	66.38
Эмэгтэй	75.84	75.1	75.44	75.78	75.96
Баян-Өлгий	73.33	73.01	73.12	73.11	73.33
Үүнээс: Эрэгтэй		70.12	70.31	70.31	70.58
Эмэгтэй		75.36	75.38	75.36	75.54

Эрэгтэйчүүдийн нас барах магадлал эмэгтэйчүүдээс их байдаг учир нас ахих тусам

хүйсний харьцаа буурч байдаг. Улсын хэмжээнд дундаж наслалт эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс 9.58 насаар илүү байгаа нь хүйсний харьцаанд нөлөөлж байдаг. Хүн амын улсын дундаж наслалт 2019 оныг 2015 онтой зэрэгцүүлэхэд 0.52 насаар уртассан бол манай аймгийн хүн амын дундаж наслалт 2019 оныг 2015 онтой зэрэгцүүлэхэд ижил түвшинд байна. Дундаж наслалтаар манай аймаг улсын дундажаас 2.92 насаар илүү дээгүүр байна.

1000 ХҮНД НОГДОХ ТӨРӨЛТ, НАС БАРАЛТ, СУМААР

Сумын нэр	Төрөлт				Нас баралт			
	2016	2017	2018	2019	2016	2017	2018	2019
Алтай	30.4	24.2	29.4	22.3	7.6	3.1	6.9	7.2
Алтанцөгц	21.5	28.4	26.4	26.5	5.4	5.3	2.4	5.2
Баяннуур	24.8	28.3	25.0	23.5	5.3	3.2	4.7	6.8
Бугат	29.4	24.3	29.4	29.0	5.0	6.3	7.0	5.0
Булган	28.6	24.5	31.6	27.3	5.6	4.4	5.4	5.8
Буянт	28.2	28.1	25.4	26.2	7.2	6.3	4.1	8.7
Дэлүүн	30.4	28.0	28.7	28.6	6.2	4.4	4.3	3.9
Ногооннуур	25.0	31.3	26.0	28.4	4.6	4.0	4.0	5.7
Сагсай	31.0	30.2	26.2	33.1	5.8	3.6	3.9	6.2
Толбо	24.8	27.1	26.3	32.1	6.1	3.8	4.7	4.0
Улаанхус	26.3	32.6	27.3	29.4	5.1	4.2	5.0	6.0
Цэнгэл	31.6	30.4	33.9	30.9	5.5	5.3	7.1	4.8
Өлгий	28.1	26.7	30.3	27.5	4.0	4.4	4.3	4.6
Аймгийн дундаж	28.5	28.0	29.0	17.4	5.2	4.4	4.8	3.4
Улсын дундаж	27.6	25.9	24.5	14.9	5.7	5.8	5.6	3.3



Хүн амын тоо, бүтэц шилжилтээс гадна нас баралт, төрөлтөөс шалтгаалан байнга өөрчлөгдөж байдаг. Сумдын хүн амын тоон үзүүлэлтүүдийг хоорондоо харьцуулж сумын хүн амын их багаас хамаарах хамаарал ач холбогдол багатай байдаг. Эдгээр өөрчлөлтийн тоон үзүүлэлтээс гадна 1000 хүнд ногдох промилээр илэрхийлэх нь сумдын хүн амын тооны их бага өөрчлөлтийг тусгахгүйгээр харьцуулах боломжтой болдог. 1000 хүнд ногдох төрөлт 2019 онд Сагсай, Толбо, Цэнгэл, Улаанхус, Бугат сумуудад аймгийн дунджаас 11.6-15.7 пунктээр их, нас баралт Буянт, Алтай, Баяннуур, Сагсай сумуудад аймгийн дунджаас 2.8-5.3 пунктээр их, үлдсэн бусад суманд аймгийн дундажийн ойролцоо байна. Эрүүл мэндийн салбарт шинэ техник, технологи нэвтэрч өвчтөний өвчний оношийг эрт илэрүүлэн шат шатандаа авч буй арга хэмжээ болон хүн амын дунд эрүүл мэндийн боловсролд тодорхой ахиц гарсаны зэрэг нь нөлөөлсөн ба нас баралт өнгөрсөн онтой харьцуулбал 0.4 пунктээр өс нэмэгдсэн байна.

ӨРХИЙН АМ БҮЛИЙН БАЙДАЛ

Хөдөөгийн хүн ам зах зээлээс хэт алслагдсаны зэрэгцээ боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж хязгаарлагдмал, мал аж ахуйгаас бусад ажлын байр хомс, мэдээлэл түргэн шуурхай хүргэх боломж сул байгаа нь тэдний амьдралын түвшин доройтоход хүргэж байна. Сүүлийн жилүүдэд бензин шатахууны үнэ өсч нэмэгдсэнтэй зэрэгцээн хүн амын өргөн хэрэглээний бараа, бүтээгдэхүүний үнэ өсч жилийн дүнгээр 6.2 хувь байгаа нь иргэдийн бодит орлого төдийлөн өсөхгүй байгаагийн нэг шалтгаан мөн. Байгаль цаг уурын нөлөөллөөс амьдрал ахуй нь шууд хараат байдалтай байгаа нь нүүдлийн мал аж ахуйтай, жилийн дөрвөн улирал малаа бэлчээрээр малладаг уулархаг бүс, хадлан тэжээлийн нөөц багатай манай аймгийн хувьд хөдөөгийн хүн амын амьжиргаа нь доройтож ядуурлын хамрах хүрээ тууштай буурахгүй өмнөх оноос 8.6 пунктээр өссөн байна.

Монгол улсын хүн амд амьжиргааны доод түвшингээс доогуур орлоготой хүн амын эзлэх хувь 2000 онд 39.9 хувь, 2010 онд 38.8 хувь, 2019 онд 28.4 хувь болж ядуурал харьцангуй гүнзгийрсэн байсан бол төр, засгаас ядуурлыг бууруулах, ажил эрхлэлтийг дэмжих, шинэ ажлын байр бий болгох шат дараалсан хөтөлбөр хэрэгжүүлсэний үр дүнд 2019 онд нийт өрхөд нэн ядуу өрхийн эзлэх хувь 8.6 хувиар багассан байна. Амьдралын гол эх үүсвэр нь мал аж ахуйтай шууд холбоотой хөдөөгийнхний хувьд хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үнэ болон мал, малын ашиг шим, ноолуурын үнэ бага зэрэг өссөн нь өрхийн амьжиргааг тэтгэж хүн амын орлого нэмэгдэхэд гол хүчин зүйл болж байгаа ч төв суурин газарт ядуурал нэмэгдэж ядуу өрхийн нийт өрхөд 31.8 хувийг эзэлж байна. Ядуурал бол дэд бүтцийн хөгжилтэй холбоотой ба нөгөө талаас төвөөс хэт алслагдсан аймгийн хувьд өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний өртөг өндөр байгаатай мөн холбоотой байна.

ХҮН АМЫН НИЙГМИЙН ЗАРИМ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Үзүүлэлтүүд	2016	2017	2018	2019	$\frac{2019}{2018} \%$
Хөдөлмөр эрхлээгүй хүн ам	4067	6570	7014	8228	117.3
Ядуу өрхийн тоо	7184	8596	8847	7728	87.4
Нэн ядуу өрхийн тоо	3993	4403	4530	4142	91.4
8 ба дээш ам бүлтэй өрх	1054	1119	1236	1330	107.6
Өрх толгойлсон эмэгтэй	1822	1879	1743	1785	102.4
Ганц бие өрхийн тоо	254	504	573	455	79.4
Хөгжлийн бэрхшээлтэй иргэд	4564	4608	4168	4345	104.2
Хагас өнчин хүүхдийн тоо	1862	1937	2039	2022	99.2
Бүтэн өнчин хүүхдийн тоо	273	283	200	191	95.5

*-урьдчилсан тоо

Өмнөх жилүүдэд харьцангуй өвөлжилт хэвийн, малын ашиг шимийн бүтээгдэхүүний үнэ нэмэгдсэн, төрөөс малчдын орлогыг нэмэгдүүлэх зорилгоор ноос, ноолуурын үнийн зөрүүг олгож эхэлсэн нь мал бүхий иргэдийн амьжиргааг дэмжиж тэтгэсэн бодлого болсон байна. Манай аймгийн нийт хүн амын 63.0 хувь нь сумын төв, хөдөө амьдардаг ба тэдний амьжиргаа нь мал аж ахуйтай шууд холбоотой учраас цаг агаарын өөрчлөлт, мал, махны үнэ болон ашиг шимийн үнийн өөрчлөлтөөс шууд хамааралтай байна.

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛИЙН ТӨРӨЛ


Хөгжлийн бэрхшээлийн төрөл	2017	2018	2019	Эмэгтэй	Төрөлхийн	Олдмол
Хөгжлийн бэрхшээлтэй хүний тоо	4608	4168	4345	2098	2362	1983
Харааны	440	403	444	151	326	118
Ярианы	201	264	230	118	205	25
Сонсголын	295	280	279	118	174	105
Хөдөлгөөний	1164	924	957	504	656	301
Сэтгэц	619	507	451	203	320	131
Хавсарсан	367	519	338	163	174	164
Бусад	1522	1271	1646	841	507	1139

2019 онд аймгийн дүнгээр нийгмийн эмзэг бүлэгт ордог бүтэн өнчин хүүхдийн тоо 191 болж өмнөх оноос 4.5 хувиар буурч, харин хагас өнчин хүүхдийн тоо 2022 болж өмнөх жилийнхээс 0.8 хувиар буурсан байна.Өрх толгойлсон 1785 эмэгтэй байгаа нь 2018 оноос 42 өрх 2.4 хувиар нэмэгдсэн байна.Хөгжлийн бэрхшээлтэй хүний тоо 2016 онд 4564, 2017 онд 4608, 2018 онд 4168, 2019 онд 4345 болж 4.2 хувиар нэмэгдэж өссөн байна.Хөгжлийн бэрхшээлтэй хүний 48.3 хувийг эмэгтэйчүүд, 54.4 хувийг төрөлхийн, 45.6 хувийг олдмол хөгжлийн бэрхшээлтэй хүн эзэлж

байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг төрлөөр үзвэл 10.2 хувийн харааны, 22.0 хувийг хөдөлгөөний, 10.4 хувийг сэтгэцийн өөрчлөлттэй хүн, 5.3 хувийг ярианы, 6.4 хувийг сонсголын, 7.8 хувийг хавсарсан, 37.9 хувийг бусад төрлийн хөгжлийн бэрхшээлтэй хүн эзэлж байна.

ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ТОО

Сумын нэр	2016	2017	2018	2019	Үүнээс: Эмэгтэй	Хөгжлийн бэрхшээлийн төрөл	
						Төрөлхийн	Олдмол
Алтай	79	78	77	77	40	69	8
Алтанцөгц	88	92	78	113	51	51	62
Баяннуур	302	353	350	345	152	217	128
Бугат	196	200	197	199	95	137	62
Булган	544	540	475	402	212	124	278
Буянт	158	157	192	193	87	104	89
Дэлүүн	401	389	370	335	136	186	149
Ногооннуур	392	394	205	219	114	131	88
Сагсай	148	145	176	196	95	62	134
Толбо	446	368	354	384	191	80	304
Улаанхус	492	404	355	347	172	247	100
Цэнгэл	306	402	299	417	153	417	
Өлгий	1012	1086	1040	1118	600	537	581
Дүн	4564	4608	4168	4345	2098	2362	1983



ХҮН АМ ӨРХИЙН БҮРТГЭЛ-ХҮН АМ ӨРХИЙН МЭДЭЭЛЛИЙН САН

Хүн ам өрхийн бүртгэл нь засаг захиргааны анхан шатны нэгжид Багийн засаг дарга нар эрхлэн хөтөлдөг анхан шатны бүртгэл бөгөөд тухайн өрхөд байгаа бүх хүний мэдээллийг бүртгэх бөгөөд тухайн оны суурин хүн амын тоог тодорхойлох, анхан шатны мэдээлэл учраас цахим санд бүрэн оруулах, баяжилт хийх, шинэчилж байх нь их чухал байдаг. Хүн амын тооллого хоорондын хүн амын тоог хянах, суурин хүн ам, өрх, нийгмийн үзүүлэлтүүдийн талаархи мэдээллийн санг бүрдүүлэх, мэдээллийн эх үүсвэр нь хүн ам өрхийн бүртгэлийн дэвтэр юм. Хүн ам орон сууцны 2020 оны улсын тооллогын бэлтгэл ажлын хүрээнд шинэчлэгдсэн хүн ам өрхийн бүртгэлийн дэвтэрийг өрх бүрээр хөтлүүлэх ажлыг зохион байгуулан сургалт хийж хүн ам өрхийн бүртгэлийн дэвтэрийг сум, багуудад хуваарилан олгож, шинэ үзүүлэлтүүдийг нөхөж оруулах, алдааны протоколд гарсан зөрүүтэй мэдээлэлүүдийг тодтогон засах, хүн ам, өрхийн мэдээллийн санг сайжруулах чиглэлээр ХАНСГазрын хүн ам, орон сууцны тооллогын товчооны хүргүүлсэн яам, тамгын газар, автотээврийн үндсэний төвийн мэдээллийн сантай зэрэгцүүлсэн зөрүүтэй мэдээллийг засварлах, тодруулах, баяжуулах, лавлах чиглэлээр томоохон хэмжээний ажлууд хийгдсэн. Үүнд:

- ✓ Хөдөлмөр, халамж үйлчилгээний ерөнхий газрын мэдээллийн сантай зэрэгцүүлсэн хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг хөгжлийн бэрхшээлийн төрөлөөр.
- ✓ Эрүүл мэндийн яамны мэдээллийн сантай зэрэгцүүлсэн тодруулга.
- ✓ Автотээврийн үндэсний төвт бүртгэлтэй автомашины тодруулга.
- ✓ Хүн амын санд байгаа ажиллагсадыг ажил мэргэжлээр кодлох.
- ✓ Орон сууц байшингийн тооллогын ажилд хэрэглэх гудамжны оноосон нэр, хаяг, хөдөөгийн өрхүүдийн байршил тодорхойлох тодруулга
- ✓ Гадаад төрсөн ЦЦ регистртэй хүүхэдүүд болон уургийн овгийн УБЕГ сангаас зөрүүтэй хүмүүсийн жагсаалт зэрэг ажлууд хийгдсэн.

Хүн ам орон сууцны 2020 оны улсын тооллогын асуулгын хуудасанд шинээр нэмэгдсэн 9 үзүүлэлтүүдийг засаг захиргааны анхан шатны нэгжийг хариуцсан Багийн Засаг дарга хэрхэн үнэн зөв нөхөх талаар гарын авлага, заавар бэлтгэж сумуудад хүргүүлсэн.

Хүн ам, өрхийн мэдээллийн сангийн бүрдэлт, баяжилт 2019 оны жилийн эцсийн байдлаар:

Үзүүлэлт	2019 он
Ш4.1 Баяжилт, шилжилт хөдөлгөөний бүртгэл	98.2
Баяжилт	98.2
ХАӨМС-ийн төрөлт	2696
УБЕГ-ын төрөлт	2732
ХАӨМС-ийн нас баралт	606
УБЕГ-ын нас баралт	510
Шилжилт хөдөлгөөний бүртгэл	224
Шилжилт 6 сараас дээш хугацаагаар баталгаажаагүй хүн ам	48
Шилжилт баталгаажаагүй нийт хүн ам	42
Шилжилт 6 сараас дээш хугацаагаар хүлээгдэж буй хүн ам	66
Шилжилт хүлээгдэж буй нийт хүн ам	68

Ш4.2 ХАӨМС-ийн чанар	92.0
Үзүүлэлтийн алдаа	7197
Хүн амын үзүүлэлтийн алдаатай хүний тоо	7143
Өрхийн үзүүлэлтийн алдаатай өрхийн тоо	54
Өрхийн цэг тэмдэглэлт	10

Хүн ам, өрхийн мэдээллийн сангийн баяжилтыг тогтмол хийж 2019 онд шинээр төрсөн 3024 хүүхдийн мэдээлэлийг нэмж, нас барьсан 502 хүнийг хүн амын мэдээллийн сангаас хасаж, шилжиж ирсэн 199 хүн, шилжин явсан 214 хүний шилжих хөдөлгөөнийг хийж, хүн амын болон өрхийн үзүүлэлтүүдийн дутуу үзүүлэлтийг алдааны протоколыг үндэслэн 1448 алдааг сумдын төрийн сангийн төлөөлөгч нартай хамтран засаж баяжилтыг хийсэн.Энэ алдаанууд шинээр төрсөн хүүхдийн хувьд хөгжлийн бэрхшээлтэй эсэх, нийгмийн халамжид хамрагдсан эсэхийг асуух алдаа, нэмж оруулах болгонд тодруулдаг ба, мөн ХАӨМСанд байгаа хүүхэдүүдээс 15 нас хүрэхэд ажил эрхлэлт, орлогын эх үүсвэр зэргийг асууж алдааны протоколд гардаг учир бүрэн дуусдаггүй, сар болгон нэмэгдэж шинэчлэгдэж байгаа үзүүлэлтүүд болно.Газар зүйн мэдээллийн санд хүн ам өрхийн бүртгэлийн мэдээллийн санд байгаа өрхийн байршил тодорхойгүй 328 өрхийн байршлыг нэмж тэмдэглэн тусгасан болно.

ДҮГНЭЛТ

2019 оны жилийн эцсийн байдлаар аймгийн суурин хүн амын тоо 103.9 мянга болж урьд оныхоос 143 хүнээр буюу 0.1 хувиар нэмэгдсэн. Энэ нь тухайн жилийн хүн амын ердийн хөдөлгөөнийг бүрэн тусгаж, хүн ам өрхийн мэдээллийн санд төрөлт, нас баралтыг улсын бүртгэлийн хэлтсээс сар бүр гаргуулан авч цахим санд оруулж, иргэний мэдээллийн сангийн зөрүүг арилгаж, бичиг баримтын зөрчилтэй хүмүүсийн зөрчлийн арилгуулж мэдээллийн санд тусгагдаж цэгцлэгдсэн, сүүлийн жилүүдэд ялангуяа 2019 оны төрөлт улсын дунджаас дээгүүр байгаа ба 1000 хүнд ногдох төрөлт 30.2, нас баралт 5.6, цэвэр өсөлт 24.7 болсон нь өмнөх оны мөн үеэс 1000 ногдох төрөлт 1.1 пунктээр, нас баралт 0.8 пунктээр, хүн амын ердийн цэвэр өсөлт 0.3 пунктээр тус тус өссөн байна.Суурин хүн амын тоо 143 хүнээр буюу 0.1 хувиар, өрхийн тоо ялимгүй бага зэрэг өсөхөд 6 сараас дээш хугацаагаар гадаадад амьдарч буй хүн амын тоо 5250 болсон нь гадаад шилжилт хөдөлгөөн нэмэгдсэнтэй холбоотойгоор суурин хүн амын тоо төдийлөн өсөөгүй байна. Ажиллах хүчний судалгааны үр дүнгээр тодорхойлогддог хөдөлмөрийн статистикийн үзүүлэлтүүд өнгөрсөн оноос буурч гарсан ба үүнд эдийн засгийн идэвхтэй хүн ам 39.0 хувиар, ажиллагсдын тоо 47.1 хувиар тус тус буурснаас улбаалан ажилгүй иргэний тоо 17.3 хувиар, ажилгүйдлийн түвшин 192.1 хувь буюу 1.9 дахин тус тус өсч нэмэгдсэн байна.Ажиллагсдын тоо 25779 болж өмнөх оноос 47.1 хувиар багасаж, ажилгүйчүүдийн тоо 8228 байгаа нь өмнөх оноос 17.3 хувиар өсч, ажилгүйдлийн түвшин 24.2 хувьд хүрсэн нь улсын дунджаас 2.4 дахин их байна. Аймгийн нийт хүн амын 63.7 хувийг хөдөлмөрийн насны хүн ам эзэлж байгаа ажиллах хүчний хангалттай нөөц байгааг харуулж байна.

Хөдөлмөрийн насны 63683 хүний 25779 хүн буюу 40.5 хувь нь албан ба албан бус хөдөлмөр эрхэлж эдийн засгийн идэвхтэй байгаа ба 12.9 хувь нь ажил хөдөлмөр эрхэлдэггүй, ажил идэвхтэй хайж буй ажилгүй иргэн байна. Эдийн засгийн идэвхгүй хүн ам буюу сургуульд суралцаж байгаа, гэрийн ажилтай, өндөр настан, өндөр насны тэтгэвэр тогтоолгосон, хөгжлийн бэрхшээлтэй болон ажил хайх итгэл алдарсан зэрэг шалтгаанаар тухайн хугацаанд ажиллах хүчинд хамаарахгүй хөдөлмөрийн насны хүн амын тоо 43725 болж өмнөх оноос 1.8 дахин өссөн байна. Аймгийн хөдөлмөр, халамж үйлчилгээний газар болон сумдын засаг даргын тамгын газарт бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо жилийн эцсийн байдлаар 1221 байгаа нь өнгөрсөн оны мөн үетэй

харьцуулахад 171 хүнээр буюу 16.3 хувиар өссөн байна. Нийт бүртгэлтэй ажилгүйчүүдийн 46.2 хувийг эмэгтэйчүүд, 50.0 орчим хувийг 15-34 насны залуучууд, үүний 17.1 хувь нь дээд боловсролтой залуучууд эзэлж байна.

Жилийн эцсийн мал тооллогын үр дүнгээр жилийн дөрвөн улирал малаа өөрөө малладаг малчин өрх, малчдын тоо жилээс жилд багасгаж байгаа 2019 онд 8703 болж өмнөх оноос 25 өрөөр буюу 0.3 хувиар, малчдын тоо 247 буюу 1.8 хувиар тус тус багассан байна, залуу малчид буюу 16-34 насныхан өмнөх оноос 404 буюу 8.1 хувиар буурсан байна. Тийм учир төр засгаас малчдын залуу халааг бэлтгэхэд онцгой анхаарахгүй бол мал аж ахуйн салбарт хүндрэл бэрхшээл гарах төлөвтэй байна. Малчдад улсаас ноосны урамшууллыг зөвхөн малчин өрхүүдэд олгодог болсон мөн сүүлийн жилүүдэд хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний үнэ, түүний дотор ноолуурын үнэ гадаад зах зээлээс хамаарч хэлбэлзэлтэй буурч байгаа нь малчин өрхийн орлого болон амьжиргааны эх үүсвэрт нөлөөлж байна. Хөдөөгийн хүн ам зах зээлээс хэт алслагдсаны зэрэгцээ боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж хязгаарлагдмал, мал аж ахуйгаас бусад ажлын байр хомс, мэдээлэл түргэн шуурхай хүргэх боломж сул байгаа нь тэдний амьдралын түвшин доройтоход хүргэж байна. Сүүлийн жилүүдэд бензин шатахууны үнэ өсч нэмэгдсэнтэй зэрэгцээн хүн амын өргөн хэрэглээний бараа, бүтээгдэхүүний үнэ өсч жилийн дүнгээр 6.2 хувь байгаа нь иргэдийн бодит орлого төдийлөн өсөхгүй байгаагийн нэг шалтгаан мөн. Байгаль цаг уурын нөлөөллөөс амьдрал ахуй нь шууд хараат байдалтай байгаа нь нүүдлийн мал аж ахуйтай, жилийн дөрвөн улирал малаа бэлчээрээр малладаг уулархаг бүс, хадлан тэжээлийн нөөц багатай манай аймгийн хувьд хөдөөгийн хүн амын амьжиргаа нь доройтож ядуурлын хамрах хүрээ тууштай буурахгүй өмнөх оноос 8.6 пунктээр өссөн байна. 2019 онд аймгийн дүнгээр нийгмийн эмзэг бүлэгт ордог бүтэн өнчин хүүхдийн тоо 191 болж өмнөх оноос 4.5 хувиар буурч, харин хагас өнчин хүүхдийн тоо 2022 болж өмнөх жилийнхээс 0.8 хувиар буурсан байна. Өрх толгойлсон 1785 эмэгтэй байгаа нь 2018 оноос 42 өрх 2.4 хувиар нэмэгдсэн байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүний тоо 2016 онд 4564, 2017 онд 4608, 2018 онд 4168, 2019 онд 4345 болж 4.2 хувиар нэмэгдэж өссөн байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүний 48.3 хувийг эмэгтэйчүүд, 54.4 хувийг төрөлхийн, 45.6 хувийг олдмол хөгжлийн бэрхшээлтэй хүн эзэлж байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүнийг төрлөөр үзвэл 10.2 хувийн харааны, 22.0 хувийг хөдөлгөөний, 10.4 хувийг сэтгэцийн өөрчлөлттэй хүн, 5.3 хувийг ярианы, 6.4 хувийг сонсголын, 7.8 хувийг хавсарсан, 37.9 хувийг бусад төрлийн хөгжлийн бэрхшээлтэй хүн эзэлж байна.

Хүн ам орон сууцны 2020 оны улсын тооллогын бэлтгэл ажлын хүрээнд шинэчлэгдсэн хүн ам өрхийн бүртгэлийн дэвтэрийг өрх бүрээр хөтлүүлэх ажлыг зохион байгуулан сургалт хийж хүн ам өрхийн бүртгэлийн дэвтэрийг сум, багуудад хуваарилан олгож, шинэ үзүүлэлтүүдийг нөхөж оруулах, алдааны протоколд гарсан зөрүүтэй мэдээлэлүүдийг тодтогон засах, хүн ам, өрхийн мэдээллийн санг сайжруулах чиглэлээр ХАНСГазрын хүн ам, орон сууцны тооллогын товчооны хүргүүлсэн яам, тамгын газар, автотээврийн үндсэний төвийн мэдээллийн сантай зэрэгцүүлсэн зөрүүтэй мэдээллийг засварлах, тодруулах, баяжуулах, лавлах чиглэлээр томоохон хэмжээний ажлууд хийгдсэн.

АШИГЛАСАН НОМ, МАТЕРИАЛ

1. Баян-Өлгий аймгийн Статистикийн эмхэтгэл 2012- 2018 онууд
2. Улсын Статистикийн эмхэтгэл 2012- 2018 онууд
3. Албан ёсны болон захиргааны сар, улирал, жилийн эцсийн мэдээ
4. Статистикийн мэдээллийн нэгдсэн сан 1212.mn
5. Монгол улсын мянганы хөгжлийн шалгуур үзүүлэлтүүд
6. Хүн ам орон сууцны 2015 оны завсрын тооллогын урьдчилсан дүн мэдээ
7. Монгол улсын нийгмийн хамгааллын хөтөлбөрүүдийн хэрэгжилт, үнэлгээ
УБ хот 2016 он
8. Баян-Өлгий аймгийн хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн
тоон болон чанарын судалгаа 2018 он

_____ о О о _____